

*Бизнесийн амжилтын  
түүхийг Хөгжлийн Шийдэл  
хамт бичилцэнэ*



ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ

**ТАЙЛАН 2017**



## АГУУЛГА

|                                                  |    |
|--------------------------------------------------|----|
| Мэндчилгээ                                       | 4  |
| Хөгжлийн Шийдэл ТББ-ын бизнес загвар, үнэт зүйлс | 5  |
| Байгууллагын бүтэц                               | 8  |
| Байгууллагын үндсэн үйл ажиллагаа                | 10 |
| 2017 онд гүйцэтгэсэн ажлууд, үр дүн              | 11 |
| Хэрэгжүүлсэн төслүүд                             | 12 |
| REACH төслийн үр дүн                             | 13 |
| УБМ-Залуу бизнесийг дэмжих санаачлага хөтөлбөр   | 14 |
| Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн төв                | 15 |
| Linkage- Бизнес холболтын хөтөлбөр               | 16 |
| Бидний үйл ажиллагааны үр дүнд                   | 17 |
| Амжилтын түүхүүд                                 | 18 |
| Дараагийн алхам: бүтээмж ба тогтвортой хөгжил    | 23 |
| Хараат бус аудитын тайлан                        | 24 |
| Bizguide.mn                                      | 26 |

Энэхүү тайланд Хөгжлийн Шийдэл ТББ-ын зүгээс 2017 онд хэрэгжүүлсэн үйл ажиллагаануудын гүйцэтгэл, үр дүнг тайлагнасан болно.

## МЭНДЧИЛГЭЭ

Монгол улсад сүүлийн жилүүдэд бизнес эрхлэлт, энтрепренёршип тодорхой түвшинд ахиц үзүүлэхийн зэрэгцээ тэдгээрийг дэмжих орчин, хүчин зүтгэл олон улсын жишгээр дэвшилттэй хөгжиж байна. Ялангуяа бэлэн түүхий эд, нөөц, боломжуудыг байгаль орчинд ээлтэй технологи, инновацийн дэмжлэгтэйгээр эдийн засгийн эргэлтэд оруулан нийгэмд тус нэмэр оруулах үр ашигтай, тогтвортой хөгжлийн загваруудаар улс орныхоо хөгжилд хувь нэмэр оруулах, түүнчлэн иргэдийн амьдралын чанарыг нэмэгдүүлэхэд жижиг, дунд бизнесүүдийн үүрэг, хариуцлага маш чухал болохыг харуулж байна.

Хөгжлийн Шийдэл ТББ нь дотоод, гадаадын санхүүжүүлэгч байгууллагуудын дэмжлэгийг жижиг, дунд бизнес эрхлэгчдийг хөгжүүлэх үйл ажиллагаанд хүргэхийн тулд дэлхийн жишгийн болоод Монголын онцлогт тохируулсан хөгжлийн үйл ажиллагаануудыг загварчлан боловсруулж хэрэгжүүлдэг юм. 2017 онд хамгийн эрэлттэй нь менежментийн зөвлөгөө, бизнесийн менторинг болон зах зээл, санхүүжилттэй холбох үйлчилгээ байсан бөгөөд бүтээгдэхүүн хөгжүүлэлт, бизнес загварчлал, төсөл боловсруулах, загварчлан сэтгэхүй болон санхүүгийн боловсрол олгох сургалтууд эрчимтэй явагдсан.

2017 онд Хөгжлийн Шийдэл ТББ нь өөрийн үндсэн үйл ажиллагаанд нийгмийн энтрепренёруудыг дэмжих чиглэлийг нэмж оруулснаар жижиг, дунд бизнесүүдийн зорилгыг ашгаас гадна нийгэмд үр нөлөөтэй байх гэсэн тодорхойлолтоор баяжуулж байна. Өөрөөр хэлбэл, бизнес эрхлэлтийн шинэ хандлагыг эх орондоо нэвтрүүлэн бизнес эрхлэгчдийг хүн-төвтэй бизнес сэтгэлгээтэй болгоход чиглүүлэн хөгжүүлэх юм.

Дээрх үйл ажиллагаануудыг шинэлэг, үр дүнтэй явуулахад Хөгжлийн Шийдэл ТББ-ын бүх ажилтнуудын санаачилга, идэвх, зүтгэл маш чухал үүрэг гүйцэтгэдгийг тэмдэглэхийг хүсэж байна. Иймд манай байгууллага ажилтнуудынхаа мэдлэг, туршлага, ур чадварыг хамтрагч байгууллагуудын хамт илүү сайн хөгжүүлэн дэлгэрүүлэх замаар зорилтот харилцагчдынхаа сэтгэл ханамжийг өндөр түвшинд хүргэхийн төлөө цаашид ч ажиллах болно.

Хүндэтгэсэн,  
Гүйцэтгэх захирал  
Э. Бат-Орших

# ХӨГЖЛИЙН ШИЙДЭЛ ТББ-ЫН БИЗНЕС ЗАГВАР, ҮНЭТ ЗҮЙЛС

## БИЗНЕС ЗАГВАР



## ҮНЭТ ЗҮЙЛС

- Төрийн бус байгууллагын менежментийн соёлыг олон улсын стандартын дагуу хэвшүүлэн ажиллана.
- Харилцагч нэг бүрийн хэрэгцээнд тохирсон үнэ цэнэтэй, үр дүнд чиглэсэн бизнес хөгжлийн урт хугацааны цогц шийдлийг санал болгоно.
- Манай байгууллагын ажилтан бүр бүтээмжтэй хамтын ажиллагааг эрхэмлэдэг бөгөөд өөрсдийн идэвх, зүтгэл, санаачилгыг хүн-төвтэй арга барилаар ямагт шинэчилнэ.

## I ГИШҮҮНЧЛЭЛ

Хөгжлийн Шийдэл ТББ нь бизнес эрхлэлтийг дэмждэг дотоодын болон олон улсын сүлжээ байгууллагуудын гишүүн юм. Уг сүлжээ байгууллагуудын гишүүнчлэлд хамрагдсанаар Монгол улсад олон улсын жишиг хөтөлбөрүүдийг суурьшуулах, нөгөөтээгүүр Монголын туршлагыг олон улсад хуваалцан харилцан ашигтай санал солилцох боломжтой байдаг. Мөн дэлхийн хөгжил дэвшлийг Монголын бизнес эрхлэгчдэд таниулан олон улсын менежментийн арга барилыг сурган дэлхийд өрсөлдөх бизнесүүдийг бий болгоход чиглэдэг.



Залуусын Бизнесийг Дэмжих Санаачилга Сүлжээ байгууллага нь дэлхийн 50 гаруй орныг эгнээндээ нэгтгэсэн ашгийн бус үйл ажиллагаа явуулдаг юм. Анх ИБУИВУ-ын Уэльсийн хунтайж Чарльзийн санаачилгаар залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд чиглэж байсан бөгөөд өдгөө залуучуудыг зөвхөн ажил хайгч бус ажил олгогч болгон бэлтгэхэд менторинг, санхүүжилт болон энтрепренёршикийн сургалтын хөгжлийн үйл ажиллагаануудыг хэрэгжүүлж 2025 он гэхэд дэлхийн нэг сая залуусыг ажлын байртай болгох зорилт тавин ажиллаж байна. Хөгжлийн Шийдэл ТББ нь 2013 оноос хойш тус байгууллагын итгэмжлэгдсэн гишүүн юм.



Даян Дэлхийн Нийгмийн Энтрепренёруудын Сүлжээ байгууллага эх дэлхийн тогтвортой хөгжлийн зорилгуудыг бизнес эрхлэлттэй уялдуулан биелүүлэхийн төлөө ажиллаж байна. 2017 онд тус байгууллага нь нийт 55 гишүүнтэй байсан бөгөөд Хөгжлийн Шийдэл ТББ нь өөрийн эрхэм зорилгын хүрээнд 55 дахь гишүүнээр элссэн. Өнөө цагт бизнесийг зөвхөн мөнгөн ашгийн зорилгоор бус нийгмийн асуудлыг шийдэх замаар тогтвортой бизнес загвараар удирдан явуулах ур чадварыг энэхүү сүлжээ байгууллагаар дамжуулан түгээн дэлгэрүүлж байна.



Монголын Менежментийн Зөвлөхүүдийн Институт нь Монгол улсын мэргэшсэн зөвлөхүүдийг эгнээндээ нэгтгэсэн, Олон Улсын Мэргэшсэн Менежментийн Зөвлөхүүдийн Институтийн гишүүн байгууллага юм. Хөгжлийн Шийдэл ТББ нь 2011 онд гишүүнээр элсэж харилцагчдадаа үзүүлж буй сургалт, зөвлөгөөний үйлчилгээг олон улсын зөвлөх үйлчилгээний стандартад нийцүүлэхийн зэрэгцээ тус институтийн дэмжлэгтэйгээр багш, зөвлөхүүдээ ямагт хөгжүүлдэг.



Монголын Үндэсний Худалдаа, Аж Үйлдвэрийн Танхимын гишүүнээр элссэн 2009 оноос хойш жижиг, дунд бизнесийг дэмжих үйл ажиллагаануудад идэвхтэй хамтран ажиллаж байна.


## ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГУУДЫН ҮНЭЛГЭЭ

Хөгжлийн Шийдэл ТББ нь аливаа хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн бэлтгэл үе шат болон явцын үе шатанд олон улсын санхүүжүүлэгч, хамтрагч байгууллагуудын үнэлгээнд хамрагдаж олон улсын санхүүжүүлэгчийн шаардлагын дагуу төсөл хэрэгжүүлэх чадавхтай гэсэн дүгнэлт авсан. 2017 онд дараах байгууллагуудын зүгээс явуулсан үйл ажиллагааны болон санхүүгийн үнэлгээнд амжилттай хамрагдсан.

- Youth Business International (YBI) – Бизнес Эрхлэгч Залуучуудын Олон Улсын Сүлжээ
- United States Agency for International Development (USAID) – АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлаг
- The Asia Foundation (TAF) – Азийн Сан
- Uniterra (WUSC) – Канадын Сайн Дурын Ажилтнуудын Хөтөлбөр

# БАЙГУУЛЛАГЫН БҮТЭЦ

## ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ЗУРАГЛАЛ



## УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД

- УЗ Дарга: Бүдрагчаагийн Баяр
- УЗ Гишүүн: Цэрэнбямбаагийн Батхүү
- УЗ Гишүүн: Мандахын Цэнджав
- УЗ Гишүүн: Гүмэнжавын Цэвэгжав

## ҮНДСЭН АЖИЛТНУУД

Хөгжлийн Шийдэл ТББ нь нийт 34 үндсэн ажилтантайгаар 2017 оны үйл ажиллагаагаа хэрэгжүүлсэн.

## САЙН ДУРЫН АЖИЛТНУУД

Хөгжлийн Шийдэл ТББ нь байгуулагдсан цагаас хойш АНУ, Япон, Канад болон Их Британиас нийт 16 сайн дурын ажилтантай хамтран ажиллаад байна. 2017 онд хамгийн олон буюу 6 сайн дурын ажилтан тус байгууллагын үйл ажиллагааг дэмжин ажиллахын зэрэгцээ бизнес эрхлэгч харилцагчдад өөрсдийн мэдлэг, туршлагаа хуваалцлаа.

- Араки Шино (JICA) нийт 60 гаруй харилцагчдад борлуулалт, маркетингийн зөвлөгөө өгөв.
- Элла Аттертон (YBI) YBM хөтөлбөрийг дэмжин ажиллав.
- Миша Гофорт (Uniterra) нийгмийн энтрепренёруудыг дэмжин тусалж, 100 гаруй бизнес эрхлэгчид болон орон нутгийн иргэдэд сургалт явуулав.
- Эмили МакАаясик (Uniterra) Улаанбаатар хот болон орон нутгийн 20 кэйс дээр суурилсан жендерийн судалгаа хийв.
- Дарья Александра Боровицкий (Uniterra) бизнес эрхлэгч залуучуудын үйл ажиллагааг дэмжин ажилласан.
- Даррен Мэйжор (Uniterra) Хөгжлийн Шийдэл ТББ-ын мэдээлэл технологийн гарын авлагыг боловсруулахад туслав.
- Даниел Карамори (Uniterra) тус байгууллагын хүний нөөцийн бодлогын гарын авлагыг боловсруулахад туслав.

## САЙН ДУРЫН МЕНТОРУУД

Хөгжлийн Шийдэл ТББ нь сайн дурын бизнес менторуудыг бэлтгэн зорилтот бүлгийн бизнес эрхлэгчдэдээ зөвлөх үйлчилгээг хүргүүлдэг.



# БАЙГУУЛЛАГЫН ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА



## БИЗНЕСИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР

- ◆ YBM-Залуу Бизнесийг Дэмжих Санаачлага
- ◆ REACH-Жижиг, Дунд Бизнесийн Санхүүжилтийг Дэмжих Төсөл
- ◆ Бизнес Эрхлэгч Эмэгтэйчүүдийн Төв
- ◆ Бизнесийн Холболтын Хөтөлбөр
- ◆ Жижиг, Дунд Бизнесийг Дэмжих Төв
- ◆ Бүлэг, Хоршооны Засаглалыг Дэмжих Хөтөлбөр
- ◆ Хөдөлмөр Эрхлэлтийг Дэмжих Хувийн Бирж
- ◆ Ментор Хөтөлбөр



## БИЗНЕСИЙН ЗӨВЛӨГӨӨ, ҮЙЛЧИЛГЭЭ

- ◆ Бизнесийн үнэлгээ, судалгаа
- ◆ Стратегийн удирдлага
- ◆ Маркетингийн удирдлага
- ◆ Зах зээлийн судалгаа
- ◆ Хүний нөөцийн удирдлага
- ◆ Менежмент
- ◆ Санхүү, нягтлан бодох бүртгэл
- ◆ Зээлийн зуучлал
- ◆ Орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийг дэмжих загварчлал



## СУРГАЛТ, СЕМИНАР

### Бизнесийн сургалт

- ◆ Зөв эхлэл, цогц мэдлэг
- ◆ Зээлдэгчийн боловсрол
- ◆ Анхан шатны нягтлан бодох бүртгэл
- ◆ Санхүүгийн тайлан бэлдэх, унших
- ◆ Бизнесийн төсөл, төлөвлөгөө боловсруулах
- ◆ Өрхийн төсөв
- ◆ Хүүхдийн санхүүгийн боловсрол

### Байгууллагын сургалт

- ◆ Гайхалтай үйлчилгээ
- ◆ Шилдэг ажилтан
- ◆ Ажилтнаа тогтоон барих аргууд
- ◆ Борлуулалтыг өсгөх сэтгэлгээний өөрчлөлт
- ◆ Мэдээлэл солилцооны үнэ цэнэ
- ◆ ТББ-ын менежмент
- ◆ Бизнесийн бүлэг, хоршоодын менежмент



## 2017 ОНД ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛУУД, ҮР ДҮН

### УЛСЫН ХЭМЖЭЭНД ЗОХИОН БАЙГУУЛСАН ҮЙЛ АЖИЛЛАГААНУУД



**4-р сар:** REACH төслийн хоёр дахь жил эхлэв.

**5-р сар:** "Нийгмийн энтрепренёруудын чуулга" уулзалтыг зохион байгуулав.

**6-р сар:** "GYEC-дэлхийн өсвөрийн энтрепренёруудын тэмцээн"-ий монгол дахь сонгон шалгаруулалтыг зохион байгуулав.

**10-р сар:** REACH төслийн хүрээнд "Жижиг, дунд бизнесүүдийн санхүүжилтийг дэмжих форум"-ыг зохион байгуулав.

**11-р сар:** Сайн дурын бизнес менторуудын уулзалтыг зохион байгуулав.



## ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСЛҮҮД

### REACH-ЖИЖИГ, ДУНД БИЗНЕСИЙН САНХҮҮЖИЛТИЙГ ДЭМЖИХ ТӨСӨЛ



АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлаг (USAID)-ийн зүгээс Хөгжлийн Шийдэл ТББ-тай хамтран жижиг, дунд бизнесүүдийг санхүүгийн хувьд илүү бат бөх, тогтвортой үйл ажиллагаатай болоход шаардлагатай санхүүжилтийг банк, санхүүгийн байгууллагаас олж авахад дэмжлэг үзүүлэх зорилгоор REACH Төслийг

хэрэгжүүлж байна. Энэхүү төслийн зорилго нь олон бэрхшээлүүдээс шалтгаалан банк, санхүүгийн байгууллагаас санхүүжилт авч чаддаггүй жижиг, дунд бизнесүүдэд хэрэгцээтэй зээлийн бүтээгдэхүүн, үйлчилгээгээ авах боломж, чадавхыг нь нэмэгдүүлэхэд оршино.



### ҮЙЛ АЖИЛЛАГААНУУД

- Жижиг, дунд бизнесийн санхүүжилтэд хамрагдах ур чадварын хэрэгцээг тодорхойлох;
- Бизнесийн зээлийн бичиг баримтын бүрдүүлэлтэд дэмжлэг туслалцаа үзүүлэх;
- Жижиг, дунд бизнесийн санхүүжилтэд төр болон хувийн хэвшлийн түншлэлийг бий болгох;
- Төслийн 5 салбар нэгжээс зээлийн зуучлалын үйлчилгээ үзүүлэх;
- "Жижиг, дунд бизнесийн санхүүжилт" форум зохион байгуулах;

#### Төсөл хэрэгжих байршлууд:

Улаанбаатар хот, Баян-Өлгий, Дорнод, Дундговь, Сэлэнгэ аймаг

**Төсөл хэрэгжих хугацаа** 2016.05-2018.04 сар

## REACH ТӨСЛИЙН ҮР ДҮН

/2017 оны 12 сарын 31-ний байдлаар/

**400**

Амжилттай зуучилсан  
зээлийн тоо

**28,50**  
тэрбум ₮

Зуучилсан зээлийн хэмжээ

**112**

Бизнесийн сургалт

**59**

Үйл ажиллагаа болон  
ажил хэрэгч уулзалт

**3,946**

Зөвлөх үйлчилгээ  
үзүүлсэн цаг

### Бизнесийн хэлбэр:

**52%**

Аж Ахуйн Нэгж

**48%**

Хувиараа бизнес  
эрхлэгчид

### Байршил:

**55%**

Улаанбаатар  
хот

**45%**

Төсөл хэрэгжиж  
буй аймгууд

### Хүйс:

**37%**

Эрэгтэй бизнес  
эрхлэгчид

**63%**

Эмэгтэй бизнес  
эрхлэгчид



## ҮБМ-ЗАЛУУ БИЗНЕСИЙГ ДЭМЖИХ САНААЧЛАГА ХӨТӨЛБӨР

Хөгжлийн Шийдэл ТББ нь 2013 онд Лондон хотод төвтэй Youth Business International Олон улсын байгууллагын гишүүнээр элсэн Залуусын Бизнесийг Дэмжих Санаачлага хөтөлбөрийг Монгол улсад хэрэгжүүлж байна. Энэхүү хөтөлбөр нь 18-35 насны залуусыг нийгмийн энтрепренёр болгон хөгжүүлж бизнес эхлэх болон эрхлэхэд дэмжин ажиллах зорилготой юм.

### ҮБМ ХӨТӨЛБӨРИЙН ЗОРЬЖ БУЙ ҮР ДҮН

- Ажил хэрэгч нийгмийн энтрепренёр залуус
- Ментортой залуу бизнес эрхлэгчид
- Мэдлэг, туршлага, инноваци, хамтын үнэ цэнэ



### ҮБМ ХӨТӨЛБӨР 2017 ОНД

**1,118**

ЗАЛУУСТ ХҮРЧ

**106**

БИЗНЕС ШИНЭЭР  
БИЙ БОЛЖ

**247**

ЗАЛУУ БИЗНЕС  
ӨРГӨЖИН САЙЖИРЧ

**31**

БИЗНЕС МЕНТОР  
БЭЛТГЭЖ

**574**

ЗАЛУУСЫГ БИЗНЕСИЙН  
МЭДЛЭГ,  
УР ЧАДВАРТ СУРГАЖ

**881 сая ₮**

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ  
ГАДААД ЗАХ ЗЭЭЛЭЭС  
БОСГОСОН

## БИЗНЕС ЭРХЛЭГЧ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ТӨВ

БНСУ-ын КОЙКА байгууллагын санхүүжилтээр Азийн сан, Нийслэлийн төр захиргаа, Хөгжлийн Шийдэл ТББ, Монголын Үндэсний Худалдаа Аж үйлдвэрийн танхим, Голомт банк болон Голомт Секюритиз ХХК-тай хамтран хэрэгжүүлж буй гурван жилийн хугацаатай хэрэгжих туршилтын төсөл юм.

Энэхүү төвийн үйл ажиллагаа нь хотын эдийн засгийн хөгжилд эмэгтэй бизнес эрхлэгчдийн хувь нэмрийг нэмэгдүүлэх зорилгыг хангах болно. Хөгжлийн Шийдэл ТББ нь энэхүү төвийн өдөр тутмын үйл ажиллагааг явуулах, сургалт, зөвлөх, менторингийн холболтын үйлчилгээг хариуцан ажиллаж байна.



### Төвөөр үйлчлүүлэгчид:

**4622** Бизнесийн ур чадвар олгох сургалт

**1045** Бизнесийн зөвлөгөө

**2374** Сургалт/үйлчилгээнд чиглүүлэх сургалт

**400** Хамтын оффис

**100** Бизнес номын булан

**120** Мэдээллийн үйлчилгээ

**30** Хүүхдийн булан

**465** Менторингийн холболт

**31** Бэлтгэгдсэн ментор

## LINKAGE- БИЗНЕС ХОЛБОЛТЫН ХӨТӨЛБӨР

### 2017 ОНЫ БАЙДЛААР



**1,168**

ТЭРБУМ ₮  
БОРЛУУЛАЛТЫН  
ХЭМЖЭЭ

**202**

ХАРИЛЦАА  
ХОЛБОО  
ТОГТООСОН  
БАЙГУУЛЛАГА

**1,430**

ХАРИЛЦАГЧИЙН  
БҮТЭЭГДЭХҮҮНИЙ  
ТАНИЛЦУУЛГА,  
БОРЛУУЛАЛТ


**105**

ХАМТРАН  
АЖИЛЛАСАН  
БАЙГУУЛЛАГА

**61**


ОРОЛЦСОН  
ҮЗЭСГЭЛЭН  
ХУДАЛДАА

#### НИЙТ ХАРИЛЦАГЧИД



- Өрх толгойлсон бизнес эрхлэгч эмэгтэйчүүд
- Жижиг дунд бизнес эрхлэгчид
- Залуу бизнес эрхлэгчид

#### НИЙТ БОРЛУУЛАЛТ ХИЙГДСЭН БАРАА БҮТЭЭГДЭХҮҮН



- Ажлын хувцас, уул уурхай болон үйлдвэрлэлийн салбарын онцлог бүхий ажлын хувцаснууд
- Гар урлалын бүтээгдэхүүн
- Модон эдлэл монгол гэрийн тавилга болон монгол гэр

## БИДНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНД

/2017 оны 12 сарын 31-ний байдлаар/

**4,358**

ШИНЭ  
БИЗНЕС

**7,618**

ӨРГӨЖИН  
САЙЖИРСАН БИЗНЕС

**20,043**

ШИНЭЭР БИЙ БОЛСОН  
АЖЛЫН БАЙР

**2,2 СЯА \$**

БОРЛУУЛАЛТЫН  
ОРЛОГЫН ӨСӨЛТ

**36,2 СЯА \$**

АМЖИЛТТАЙ ЗЭЭЛИЙН  
ЗУУЧЛАЛ

**8,577**

АМЖИЛТТАЙ ЗУУЧИЛСАН  
БАНКНЫ ЗЭЭЛИЙН ТОО

**497**

БИЗНЕСИЙН БҮЛЭГ,  
ХОРШОО, ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА

**6,100**

ЗАЛУУ БИЗНЕС  
ЭРХЛЭГЧИД



ЭМЭГТЭЙ БИЗНЕС  
ЭРХЛЭГЧИД

**60%**



ЭРЭГТЭЙ БИЗНЕС  
ЭРХЛЭГЧИД

**40%**

## АМЖИЛТЫН ТҮҮХҮҮД



**Бизнес эрхлэгч Н.Энхжаргал: Бизнесийн өсөлтийг зөвлөх үйлчилгээгээр бий болгодгийг ойлгосон.**

Эгч дүүс Н.Энхжаргал, Н.Энхтуяа нар талх, нарийн боов үйлдвэрлэдэг жижиг бизнесээ хамтран эхлүүлээд "Өгөөмж Архад" ХХК-ийг байгуулжээ. Анх үйлдвэр нь хоёрхон төрлийн нарийн боовыг цөөн тоогоор хийж нийлүүлдэг байсан бол одоо 600м2 эзэмшлийн байртай, 63 төрлийн амттан, талх, нарийн боов үйлдвэрлэж Улаанбаатар хотод 300 гаруй дэлгүүрүүдээр худалдаалдаг болжээ. Үйлдвэрт ажиллагсдын 40 гаруй хувь нь анх байгуулагдсан цагаас эхлэн өнөөг хүртэл хамт тогтвортой ажиллаж байна.

Тэд Хөгжлийн Шийдэл ТББ-ын бизнес сургалтуудад тогтмол хамрагдахын зэрэгцээ шаардлагатай тусгайлсан зөвлөгөөг авч үйлдвэрлэлийг хэрхэн цаашдаа өргөжин тэлэх талаар төлөвлөгөөтэй болцгоосон. Ялангуяа үйлдвэрийн хүчин чадлыг өргөтгөх, ажлын байрыг тохижуулахад шаардлагатай хөрөнгө оруулалтыг хэрхэн зөв тооцоолон олж авах талаарх

зөвлөгөөний үр дүнд үйлдвэртээ шинэ агааржуулалтын систем болон олон төрлийн бүтээгдэхүүний гурилыг хэрчиж хэлбэржүүлдэг машиныг Итали улсаас худалдаж авсан. Шинэ ажлын орчин болоод орчин үеийн техник, технологитой болсноор үйлдвэрлэлийн гарц нэмэгдэж, борлуулалтын орлого өссөн байна.

### Б.Энхмаа: Тууштай байдал л бизнесийг хөгжүүлэх гол түлхүүр

Б.Энхмаа нь ээжийнхээ үүсгэн байгуулсан Бат-Учиг ХХК оёдлын компанийг өвлөж аван бизнесээ хөл дээр нь бат бөх зогсоохын тулд өнөөдрийг хүртэл шаргуу хөдөлмөрлөсөөр ирсэн цуцалтгүй хөдөлмөрч бизнес эрхлэгч юм.

Тэрээр захиалгаар ажлын хувцас, дүрэмт хувцас оёдог бөгөөд үйлдвэрлэж буй бүтээгдэхүүнээ илүү олон байгууллага болон хувь хүмүүст хүргэх, бизнесээ илүү зөв чиглүүлэх шаардлага тулгараад байх үедээ Хөгжлийн Шийдэл ТББ-ын Бизнес Холболтын хөтөлбөрт ханджээ. Холболтын хөтөлбөр нь түүний компанийг захиалагч байгууллагуудтай холбох гүүр болж байсан бөгөөд тэрээр өөрийн компанид ноогдсон бүхий л ажил, захиалгуудаа нягт нямбай гүйцэтгэж ирсэн билээ.


Бизнес эрхлэгч маань компаниа одоог хүртэл тасралтгүй хөгжүүлсээр үндсэн 3 ажилтан, гэрээт 7 ажилтантай, өөрийн гэсэн ажлын байртай болон үйл ажиллагаагаа амжилттай явуулж байна. Мөн дан ганц Бизнес Холболтын үйлчилгээнд хамрагдаад зогсохгүй Хөгжлийн Шийдэл ТББ-с хэрэгжүүлж буй Залуусын Бизнесийг Дэмжих хөтөлбөр, Бизнес Эрхлэгч Эмэгтэйчүүдийг Дэмжих төслүүдийн сургалт, уулзалтанд хамрагдаж бизнесийн мэдлэгээ илүү нэмэгдүүлсээр байна.



**Эрүүл, чанартай үндэсний үйлдвэрлэл эрхлэх хүсэлтэй залуу бизнес эрхлэгч**

Ө.Золжаргал нь эх орондоо аюулгүй чанартай үндэсний үйлдвэрлэл эрхлэхийг зорьж яваад хүүхэд байхдаа зуны амралтаа өнгөрүүлдэг байсан газраасаа байгалийн эрдэст цэвэр усыг савлаж зарах санаа төрсөн ажээ. Тэрээр "Манай улсад 40 гаруй цэвэр ус үйлдвэрлэдэг компани байдгаас цөөн хэд нь усаа хөдөө орон нутгаас зөөвөрлөж авч ирдэг бол ихэнх нь Улаанбаатар хотын цоргоноос л савлачихдаг. Бидний хувьд "Золотая" эрдэст усаа газрын 80 метр гүнээс гаргаж авдаг. Өөрсдийн гэсэн жижиг үйлдвэрт үндэснийхээ бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж, тухайн орон нутгаасаа ажилчид авч ажиллуулна гэдэг үнэхээр сайхан юм" гэж тэрээр хэлж байлаа.

Түүнд цаашдаа үйлдвэрийнхээ хүчин чадлыг нэмэгдүүлэхийн тулд нэмэлт тоног төхөөрөмж хэрэгтэй байсан бөгөөд Хөгжлийн Шийдэл ТББ-ын "Бизнес төлөвлөгөө" мэдээллийн уулзалтад оролцон төсөл бичин өөрт хэрэгтэй бага хүүтэй зээл авах боломж байгааг мэдэж авчээ. Манай байгууллагаас бизнес эрхлэгчдийг дэмжих хүрээнд 111 гаруй мэдээлэл өгөх уулзалт зохион байгуулж 3601 бизнес эрхлэгчид хамрагдаад байгаа билээ. Уулзалтад хамрагдсанаараа өөрт хэрэгцээтэй мэдээллийг олж аваад зогсохгүй, ижил хүсэл мөрөөдөлтэй олон залуустай танилцаж мөн хамтран ажиллах боломж гарч ирдэг юм. Золжаргал маань бага хүүтэй зээл авахаар өөрийн төслөө хэдийн бичээд эхэлсэн бөгөөд цаашдаа эрүүл чанартай хүнсийг хэрэглэгчдэд нийлүүлэхээр зорин ажиллаж байна.

**Д.Пагмасүрэн: Ментортой болсноор бизнесийн орлогоо гурав дахин нэмэгдүүлсэн.**

Эдпаур Трейд ХХК-ны захирал Д.Пагмасүрэн нь Улаанбаатар хотод тулгарч буй томоохон асуудлын нэг болох агаарын бохирдлыг бууруулахад хувь нэмрээ оруулахаар шийдэн өөрийн бизнесээ эхэлсэн юм. Тэрээр автомашинаас ялгарч буй хорт хий, нарийн ширхэгт тоосонцрыг бууруулж, шатахуун хэмнэх замаар моторыг хамгаалах зориулалттай Япон улсад үйлдвэрлэдэг бүтээгдэхүүнийг Монголын зах зээлд амжилттай нэвтрүүлэх боломжтой байна гэдгийг олж харсан байна.

2017 онд Хөгжлийн Шийдэл ТББ-ын менторингийн үйлчилгээнд хамрагдан, гарааны бизнесийн арвин туршлагатай ментор Ж.Эрдэнэбилэгтэй холбогдсон. Түүний зөвлөснөөр, Япон улсад очиж "ADPOWER" бүтээгдэхүүний үйлдвэртэй танилцсан бөгөөд тусгай эрх бүхий албан ёсны төлөөлөгчөөр Монголд ажиллах болжээ. Ментортой болсноор тэрээр бүтээгдэхүүнийхээ маркетингийн төлөвлөгөөг гаргахын зэрэгцээ маркетинг

контент хөгжүүлж, түүнийгээ олон нийтийн мэдээллийн сүлжээ болон телевизийн сувгаар сурталчилснаараа гурван сарын дараа борлуулалтын орлогоо гурав дахин нэмэгдүүлсэн байна.

Ойрын хугацаанд Пагмасүрэн нь зах зээлийн хамрах цар хүрээг өргөсгөхөөр ажиллаж байгаа бөгөөд дараагийн гурван жилийн хугацаанд Улаанбаатар хотод явж буй авто машинуудын хоёр хувьд бүтээгдэхүүнээ борлуулж, нийслэл хотын агаарын бохирдлыг бууруулахад хувь нэмрээ оруулахаар зорин ажиллаж байна.

**“Хан Брэнд” ХХК: REACH төслийн дэмжлэгтэйгээр бизнес төслөө боловсруулж шаардлагатай зээлээ авсан.**

Хүнс, Технологийн Политехникийн Коллеж нь Улаанбаатар хотын хүн амын сүүн бүтээгдэхүүний хэрэгцээг хангахын тулд “Хан брэнд” ХХК-ийг ажиллуулдаг. Анх компаниа байгуулсны дараа өдрөөс үйлдвэрийн барилга, өдөрт таван тонноос илүү сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадалтай тоног төхөөрөмжийн хэрэгцээ гарсан тул хөрөнгө оруулалт авах шаардлага тулгарчээ.

Урт хугацааны туршид хөрөнгө оруулалт хайсны эцэст бага хүүтэй зээл олсон боловч зээл авахын тулд нарийн тооцсон хөрөнгө оруулалтын төсөл бичих шаардлагатай болжээ. Тэдэнд мэргэжлийн зөвлөгөө хэрэгтэй байсан бөгөөд Америкийн Нэгдсэн Улсын Олон Улсын Хөгжлийн Агентлагийн санхүүжилттэйгээр Хөгжлийн Шийдэл ТББ-ын хэрэгжүүлж буй REACH төсөлтэй холбогдсон. REACH төслийн зөвлөгөө, сургалтад хамрагдсанаар маш түргэн хугацаанд хөрөнгө оруулалтын төслөө боловсруулж, шаардлагатай эх үүсвэрээ олж авсан. Ийнхүү үйлдвэрийн барилгаа барьж, стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүн үйлдвэрлэх тоног төхөөрөмж худалдан авч суурилуулснаар коллежийн оюутнуудыг ажлын байраар хангахын зэрэгцээ, цэвэр сүү, сүүн бүтээгдэхүүнүүдийг нийслэл хотын зах зээлд нийлүүлж байна.

Хан Брэнд ХХК нь цаашид хүүхдийн тэжээл үйлдвэрлэн нийлүүлэх дараагийн төсөлдөө анхааран ажиллаж байна.



**Aquila брэндийг санаачлагч Б. Ганхараа: Бизнес эхлүүлснээрээ тогтмол орлоготой болсон.**

Б.Ганхараа нь Бизнес Эрхлэгч Эмэгтэйчүүдийн Төв(БЭЭТ) төслийн дэмжлэгтэйгээр өөрийн бизнесээ эхлүүлсэн харилцагчдын маань нэг билээ. Тэрээр бага насны гурван хүүхдийн хамт амьдардаг бөгөөд хүүхдүүдийг нь харах хүн байхгүй учраас аргагүй эрхэнд ээлжийн ажлаасаа гарчээ.

БЭЭТ төслийн сургалтад сууж байх явцдаа одоогийн хийж буй шинэ бизнесийн санаагаа олсон бөгөөд бизнес хийхээр эргэлт буцалтгүйгээр шийдсэн тэрээр: “Ажлаасаа гарч ямар ч орлогогүй болсон намайг шантрах үед хамгийн их урам өгч, зөвлөгөө өгөн дэмжиж байсан хүмүүс бол БЭЭТ төслийнхөн байсан. 2017 онд өөрийн үйлдвэрлэсэн “Aquila” ҮХРИЙН ТОЙГНЫ ТОСТОЙ ВАННЫ БӨМБӨЛӨГ бүтээгдэхүүндээ Монгол Улсын Ашигтай Загварын Гэрчилгээг аван хамгийн түрүүнд БЭЭТ төслийнхөндөө сайхан мэдээгээ дуулгаж байлаа” хэмээн дурсамжаа хуваалцлаа.

БЭЭТ төслийн зөвлөгөө, сургалтуудад хамрагдсанаар бүтээгдэхүүнүүддээ сав баглаа боодол, хаяг шошго бий болгосон. Мөн маркетингийн болон бизнесийн төлөвлөгөөтэй болсноор борлуулалтаа нэмэгдүүлж, өөрийн гэсэн ажлын байртай болох зорилго нь мөн биелжээ. Одоо бизнесийн тогтмол орлоготой болсон тэрээр хүүхдүүдээ илүү халамжлах боломжтой болсон байна.

**Б.Ариунсанаа: “Бүтэлгүйтэл бол боломж гэдгийг ойлгосон”**

Б.Ариунсанаа анх хувийн оёдлын бизнес эрхлэх зорилгоор Холлимайнд ХХК-г үүсгэн байгуулсан ба тухайн үедээ төлөвлөж байсан бизнес нь бүтэлгүйтсэн учраас байгуулсан компаниа зөнд нь орхиж зөвхөн цаасан дээр л ашигласаар иржээ.

Тэрээр дахин бизнесээ амжилтад хүргэх гэж хичээж, шинэ санаагаа хөгжүүлэх, санхүүжилт олохоор судалж яваад Хөгжлийн Шийдэл ТББ-н хэрэгжүүлж буй Залуусын Бизнесийг Дэмжих Санаачлага (Youth Business Mongolia) хөтөлбөртэй танилцсан юм. Тэрээр боломжоо ашиглахаар сургалт зөвлөгөөнд идэвхтэй хамрагдаж өөрийн бизнест шаардлагатай мэдлэгээр өөрийн бизнесээ хөгжүүлж чаджээ. “ЗБДС хөтөлбөрийн төсөл хөтөлбөр боловсруулах сургалтад суралцан өөрийн толгойд байсан бизнес санаагаа цаасан дээр буулган бизнесийнхээ анхны баганыг босгож чадсан” хэмээн тэрээр хэлж байлаа. Хөтөлбөрийн хүрээнд бизнес эрхлэгч бүсгүй маань оёдлын тоног төхөөрөмжтэй болж, сургалтад хамрагдан мөн төслөө

бичиж 10 сая төгрөгийн санхүүжилт авч чадсан билээ.

Одоо тэрээр албан байгууллагын захиалгаар логотой цүнх, тор болон спортын цүнх үйлдвэрлэж байгаа бөгөөд түүний үүсгэн байгуулсан Холлимайнд компани цаасан дээр бус өөрийн гэсэн ажлын байртай, байнгын захиалагчтай, өөрийн гэсэн өнгө төрхтэйгээр Монгол залуусын бизнесийн эгнээд багтаад байна.

**Сонирхолоо ажил хэрэг болгосон бүсгүйн амжилтын түүх**

Д.Лхамсүрэн нь өөрийн сонирхолдоо хөтлөгдөн гэрийн эзэгтэйн ажлын хажуугаар гар урлалын схемт ном ашиглан гоёл чимэглэлийн зүйлс урлаж сурчээ. Өөртөө болон охиндоо гоёл чимэглэлийн зүйлс бага багаар урлан энэ сонирхлоо улам хөгжүүлэн суралцаар Улаанбаатар хотод зохиогдож буй томоохон үзэсгэлэн худалдаануудад өөрийн гараар урласан гоёл чимэглэлээ худалдан борлуулж эхэлсэн байна.

Бүтээгдэхүүнүүдээ худалдан борлуулж эхэлсэн цагаас бизнесээ улам өргөжүүлэн сайжруулах хэрэгцээ шаардлагатай тулгарч зах зээлийн судалгаа, шинэлэг санааг бизнес хэрхэн болгох талаар эрэлхийлэн явсаар Хөгжлийг Шийдэл ТББ-ын Өглөөний цайн уулзалтуудад идэвхтэй хамрагдаж өөрийн бизнесийн хамтрагч нар болон зөвлөн туслах ментортой болж чадсан байна. Өглөөний эртэч энэхүү уулзалтууд нь түүнд шинэ санаа, шинэлэг зөвлөмжийг олход илүү дөхөм байж өөрийн сонирхлоор эхлүүлсэн бизнесээ урам зоригтойгоор урагшлахад нь түлхэц болсоор иржээ.

Тэрээр уран дархны сургалтад хамрагдан алт мөнгө үнэт эдлэлийг гараар урлан бизнесийхээ төрлийг нэмэгдүүлэхээр ажиллаж эхэлсэн бөгөөд хөтөлбөрийн үр дүнд бизнестээ хандах хандлага, хариуцлага илүү өндөр босготой болж борлуулалт, захиалгын тоо өсөн нэмэгдэн улмаар “Индранил МАЛЦ” ХХК-г үүсгэн байгуулж гоёл чимэглэл, гар урлал, бэлэг дурсгалын бүтээгдэхүүнээрээ гадна дотоодын олон үзэсгэлэн худалдаанд амжилттай оролцсоор байна.



### Гар урлалын бизнес эрхлэгч Б.Кундыз: Аж ахуй эрхлэлтийн сургалтаар бизнес эрхлэх суурь мэдлэгтэй болсон.

Хөгжлийн Шийдэл ТББ нь Монгол улсын 21 аймагт бизнес, аж ахуй эрхлэлтийн сургалт, зөвлөгөөг хүргэдэг бөгөөд 2017 онд Баян-Өлгий аймгийн бизнес эрхлэгчдийг дэмжин ажилласан юм. Б.Кундыз нь аж ахуй эрхлэлтийн сургалтад хамрагдсан бизнес эрхлэгчдийн нэг бөгөөд тэрээр уламжлалт гар урлал, эсгийн эдлэл урлахын зэрэгцээ, бүтээгдэхүүнүүдээ борлуулах дэлгүүр ажиллуулдаг юм.

Аж ахуй эрхлэлтийн сургалтаар бизнес эрхлэх суурь мэдлэгтэй болсны зэрэгцээ банкны зээлд анх удаа хамрагдан бизнест шаардлагатай эргэлтийн хөрөнгөө нэмэгдүүлсэндээ тэрээр маш их баяртай байгаагаа илэрхийлсэн юм. Мөн бүтээгдэхүүний нэр төрөл, гарцыг нэмэгдүүлэх боломжтой болсон байна.

Цаашид бизнесээ томоохон зах зээлтэй ойртуулахад шаардлагатай мэдлэг, мэдээллийг олж авах үүднээс илүү олон бизнесийн сургалт, зөвлөгөө авахаар төлөвлөөд байна.



### Бизнес эрхлэгч Р.Мөнхтогтох: Бизнесээ илүү хурдан хөгжүүлэхэд банкны зээл чухал үүрэгтэй.

Р.Мөнхтогтох нь такси үйлчилгээний бизнес эрхлэгч билээ. Тэрээр хот хоорондын таксины жолоочоос ажлын анхны гараагаа эхэлж байсан бөгөөд нийтийн тээврийн үйлчилгээг түргэн шуурхай, найдвартай үйлчилгээтэй болгох мөрөөдөлтэй тэрээр "Мөнх" такси үйлчилгээний компаниа байгуулсан юм. Одоогоор 160 таксигаар нийслэл хотын нийтийн үйлчилгээнд томоохон хувь нэмэр оруулж байна.

Тэрбээр Хөгжлийн Шийдэл ТББ-ын холболтын үйлчилгээний нэг хэсэг болох зээлийн зуучлалын үйлчилгээний дэмжлэгтэйгээр хамтрагч арилжааны боломжийн нөхцөлөөр шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрээ олж авсан юм. Мөн Хөгжлийн Шийдэл ТББ-ын зүгээс зохион байгуулдаг бизнес төслийн сургалтад хамрагдан менежментийн чадвараа сайжруулсаар байна.



### "Пүнтүүз" брэндийг үүсгэн байгуулагч Л.Тэрбиш: Ажил хайгчаас ажил олгогч болсон.

Л.Тэрбиш бол 61 настай, гялалзсан нүдтэй, эрч хүчээр дүүрэн бизнес эрхлэгч эмэгтэй юм. Тэрээр нөхрөө машины ослоор алдан, түүнтэй зэрэгцээд ажлаасаа халагдсан, бага насны гурван хүүхэдтэй өрх толгойлсон эмэгтэй гэх хүнд хэцүүг даван туулсны эцэст өөрөө ажил олгогч үйлдвэрлэгч болж чадсан үлгэр жишээч бизнес эрхлэгч эмэгтэй юм.

Хүүхдүүдээ өсгөхийн тулд хорин жилийн турш импортын пүнтүүз худалдаалсан туршлагатай тэрээр өөрийн гэсэн бизнестэй болохоор шийдэн "Пүнтүүз" брэндийг үүсгэн байгуулсан юм. Энэ үед тэрээр Хөгжлийн Шийдэл ТББ-аас дэмжлэг хүсэн бизнес төлөвлөгөөтэй болж шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг олж авснаар пүнтүүзний үйлдвэрээ байгуулан шинээр 15 ажлын байр бий болгосон юм. Одоогоор "Пүнтүүз" үйлдвэр сар бүр арван тонн пүнтүүз үйлдвэрлэдэг бөгөөд цаашдаа хатаах үйлдвэртэй болж, ажилчдын тоогоо нэмж, ашгаа хоёр дахин нэмэгдүүлэх зорилготой ажиллаж байна. Түүний амжилтын жор бол "цуцалтгүй хөдөлмөр" хэмээн баяртайгаар хуваалцсан юм.



## ДАРААГИЙН АЛХАМ: БҮТЭЭМЖ БА ТЕХНОЛОГИ

Аливаа улс оронд төрийн бус байгууллагуудын чадавх, үйл ажиллагаа нөлөөтэй, хүчтэй байх тусам тухайн улсын хөгжлийн чиг хандлага, иргэдийн амьдралын чанар төдий чинээ сайн үзүүлэлттэй байдаг. Иймээс



төрийн бус байгууллагуудын хэрэгжүүлж буй төслүүдийн үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэхэд бүтээмж чухал үүрэг гүйцэтгэдэг. Ялангуяа ажилтан, нэгж, байгууллага, бүтэц болон тогтолцооны түвшинд байгууллагын тогтвортой хөгжил, урт хугацааны үр дүнг илтгэх бүтээмжийн загварчлалыг хөгжүүлэн бий болгох шаардлагатай юм. Иймд Хөгжлийн Шийдэл ТББ-ын зүгээс цаашид хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүд болон хамтран зохион байгуулж буй үйл ажиллагаануудад бүтээмжийг чухалчлан авч үзнэ. Үүнийг бий болгоход байгууллагын удирдлагын зүгээс бүтээмжийг нэмэгдүүлэх олон улсын стандартыг нэвтрүүлэн хэвшүүлэх төлөвлөгөөг гарган ажиллаж байна.

Бүтээмжийг нэмэгдүүлэхэд технологи маш ач холбогдолтой. Хөгжлийн Шийдэл ТББ нь технологийн дэмжлэгтэйгээр бизнесийн чиглэлийн мэдээллийн үйлчилгээ болон харилцагчийн тоо бүртгэлийн үйл ажиллагааг гүйцэтгэж байна. Цаашид төслүүдийн үр шимийг хүртэгсдийн тоог нэмэгдүүлэх, үйл ажиллагааны давтамжийг нэмэгдүүлэх, үйл ажиллагааны агуулга, хэлбэрийн шинэчлэлийг тогтмолжуулах, бүх оролцогч талуудтай хамтын ажиллагааг бэхжүүлэх, эргэх холбоо, хяналтыг сайжруулах зэрэг арга хэмжээнүүдийг технологийн дэмжлэгтэйгээр гүйцэтгэх нөхцөлийг бүрдүүлэн ажиллана. Үүний үр дүнд тогтвортой хөгжлийн зорилгуудын хүрээнд орон нутгийн хөгжлийн бодлогод хүн-төвтэй зарчмыг нэвтрүүлэх, жижиг, дунд бизнесүүдийн өрсөлдөх чадавхыг нэмэгдүүлэх болон өрхийн амьдралын чанарыг сайжруулах ажлууд өргөн хүрээгээр хүртээмжтэй, оролцоотой явагдана гэдэгт итгэлтэй байна.

# ХАРААТ БУС АУДИТЫН ТАЙЛАН

**ДАЛАЙВАН АУДИТ**Аудит, баталгаажуулалт, хөрөнгийн болон  
бизнесийн үнэлгээ, зөвлөх үйлчилгээМонгол Улс, Улаанбаатар хот-16066  
Баянгол дүүрэг, Амарсалангийн гудамж-5  
Утас: 70005401, 70005404, 70005405  
Факс: +976-70005403  
Э.Шуудан: info@dalaivanaudit.mn  
Вэб хуудас: www.dalaivanaudit.mn

## ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

### “Хөгжлийн Шийдэл” ТББ -ын Удирдах Зөвлөлд

#### Бидний дүгнэлт

Бид 2017 оны 12 дугаар сарын 31-ээр тасалбар болгосон баланс, үр дүнгийн тайлан болон цэвэр хөрөнгийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон гол чухал нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдсэн “Хөгжлийн Шийдэл” ТББ-ын санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэж байгаагаар эдгээр санхүүгийн тайлангууд нь бүхий л материаллаг асуудлаар “Хөгжлийн Шийдэл” ТББ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдал, тухайн жилийн үр дүн, цэвэр хөрөнгийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартад нийцүүлэн Сангийн Яамны 385-р тушаалаар баталсан Төрийн бус байгууллагын нягтлан бодох бүртгэл, тайлагналын зааврын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-ын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Энэ стандартын дагуу бидний хүлээх үүрэг хариуцлагыг энэхүү тайлангийн Санхүүгийн Тайлангийн Аудитад Хүлээх Аудиторын Үүрэг Хариуцлага хэсэгт харуулсан. Бидний олж авсан аудитын нотолгоо нь аудитын дүгнэлт гаргахад хангалтай бөгөөд зохистой гэж үзэж байна.

#### Хараат бус байдал

Бид Олон Улсын Ёс зүйн Хорооноос гаргасан санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн шаардлагуудын дагуу Хөгжлийн Шийдэл ТББ-аас хараат бус байж, эдгээр шаардлагуудын дагуух ёс зүйн бусад үүрэг хариуцлагуудыг мөрдөж ажилласан.

#### Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээллийн хувьд хариуцлага хүлээнэ. Бусад мэдээлэлд Хөгжлийн Шийдэл ТББ-ын жилийн тайланг хамааруулах бөгөөд үүнд санхүүгийн тайлан болон аудиторын дүгнэлт тайлан багтаагүй. Аудиторын тайлан гарахаас өмнө Хөгжлийн Шийдэл ТББ-ын 2017 оны жилийн үйл ажиллагааны тайлан эцэслэж гараагүй.

#### Санхүүгийн тайлангийн талаар Удирдлага болон засаглах удирдлагын хүлээх хариуцлага

Удирдлага нь СТОУС-ын дагуу санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах үүрэг хүлээхээс гадна залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэхэд зайлшгүй чухал гэж тодорхойлсон дотоод хяналтуудыг тодорхойлно.

**ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (үргэлжлэл)**

Санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлага, төлбөрийн чадваргүй болох эсвэл үйл ажиллагаагаа зогсоохоос шийдсэнээс бусад тохиолдолд, тасралтгүй байх зарчмын дагуу Хөгжлийн Шийдэл ТББ-ын үйл ажиллагааг зогсолтгүй явуулах байгууллагын чадамжийг үнэлэх үүргийг хүлээнэ.

Компанийн засаглах удирдлага нь санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүргийг хүлээнэ.

*Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх хариуцлага*

Бидний зорилго бол санхүүгийн тайлан нь бүхэлдээ залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй бэлтгэгдсэн эсэх талаар хамгийн боломжит баталгааг олж авах, өөрийн дүгнэлтийг илэрхийлсэн аудиторын тайланг бэлтгэх явдал юм. Хамгийн боломжит баталгаа гэдэг нь дээд түвшний баталгаа боловч АОУС-ын дагуу хийж гүйцэтгэсэн аудит нь оршин байгаа буруу тайлагналыг байнга илрүүлнэ гэсэн баталгааг өгөхгүй юм. Залилан эсвэл алдаанаас шалтгаалан буруу тайлагнал үүсэж болох ба дангаараа эсвэл нийтдээ материаллаг гэж үзсэн бол санхүүгийн тайланд тулгуурлан хэрэглэгчийн гаргах эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх боломжтой юм.

АОУС-ын дагуу бид аудитын туршид мэргэжлийн үл итгэх хандлагыг баримтлан мэргэжлийн шийдэл гаргаж ажилласан. Мөн бид дараах ажлуудыг хийсэн:

- Санхүүгийн тайланд залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагнал байх эрсдэлийг тодорхойлж үнэлсэн, тэдгээр эрсдэлүүдэд хариу аудитын горимуудыг тодорхойлж хэрэгжүүлсэн, мөн дүгнэлтийн үндэслэл болох аудитын хангалттай нотолгоог олж авсан. Зөвхөн нэг алдаанаас бус үгсэн хуйвалдсан үйл ажиллагаа, хуурамчаар үйлдэх, санаатай орхигдуулах, дотоод хяналтыг үл хэрэгсэх эсвэл гуйвуулах зэрэг залилангаас шалтгаалсан материаллаг буруу тайлагналыг илрүүлэхгүй байх эрсдэлтэй.
- Аудитын зохистой горимыг боловсруулахын тулд байгууллагын дотоод хяналтын тогтолцооны талаар ойлголт олж авсан, гэхдээ Хөгжлийн Шийдэл ТББ-ын дотоод хяналтын үр дүнтэй байдалд дүгнэлт өгөх зорилгогүй.
- Байгууллагын ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, удирдлагын хийсэн тооцоолол болон тодруулгын зохистой байдлыг үнэлсэн.
- Хэрэв байгууллагын тасралтгүй байх чадавхад материаллаг тодорхойгүй байдал байна гэж үзвэл бид санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгын хэсэгт анхаарлаа хандуулах болно. Хэрэв энэ талаар холбогдох тодруулгад хангалттай дурдаагүй байвал бид аудитын дүгнэлтээ өөрчлөх болно. Бидний өгөх аудитын дүгнэлт нь аудиторын тайланг огноолох өдөр хүртэлх аудитын нотолгоонд суурилна. Иймд Хөгжлийн Шийдэл ТББ-ын тасралтгүй байх чадварт нөлөөлөх нөхцөл байдал ирээдүйд үүсэж болох юм.
- Санхүүгийн тайлангийн бүтэц, агуулга, толилуулга болон тодруулгыг бид бүхэлд нь шалгаж санхүүгийн тайлан нь ажил гүйлгээ ба үйл явдлыг үнэн зөв харуулсан эсэхийг үнэлсэн.

Ерөнхий Захирал, МНБ  
УЛААНБААТАР ХОТ  
Ц.Жигдэн  
  
2018 оны 6 дугаар сарын 04  
1115208209 2018-09



# BIZGUIDE.MN

BIZGUIDE

Бидний тухай | Холбоо барих | Монгол English

Сайнаас хайлт хийх...

